




## Хэнтий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны 09 дугаар сарын байдлаар)



### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж байгаа ажилгүйчүүд тайлант сард 450 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 201 хүнээр буюу 69.1 хувиар буурсан байна.

Зураг.1 Ажил хайгч иргэд, жил бүрийн  
9 сарын байдлаар



Нийт ажилгүйчүүдийн 33.3 хувь нь дээд, 4.5 хувь нь тусгай дунд, 9.4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 37.3 хувь нь бүрэн дунд, 10.4 хувь нь бүрэн бус дунд, 3.2 хувь нь бага боловсролтой, 1.9 хувь нь боловсролгүй хүмүүс байна.


Зураг.2 Ажил хайгч иргэд, боловсролын түвшнээр  
9 сарын байдлаар





Нийт ажилгүйчүүдийн 57.8 хувь нь эмэгтэйчүүд, 58.8 хувь нь 15-35 хүртэлх насны залуучууд байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 3.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг.3 Ажил хайгч иргэд, насны бүлгээр  
9 сарын байдлаар



#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

##### **Бүртгэлтэй ажилгүй иргэн**

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.




#### **I.2 Нийгмийн даатгал, халамж**

Энэ улиралд 13434.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлөвлөгөөтэйгээс 16386.5 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж, төлөвлөгөө 122.0 хувиар биеллээ. Нийгмийн даатгалын шимтгэлийн нийт авлагын эцсийн үлдэгдэл 1264.2 сая төгрөг байгаа нь төсвөөс 277.8 сая төгрөг, ААН байгууллагаас 986.4 сая төгрөг тус тус байна.

Нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын мэдээгээр энэ улиралд нийгмийн халамжийн сангаас 47355 хүнд 9061,8 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлтийг олгосон байна. Нийт халамжийн сангийн 26,0 хувийг тэтгэвэрт, 19,0 хувийг тэтгэмж, 19,0 хувийг ахмад настан, тахир дутуу хүмүүст үзүүлэх хөнгөлөлтөд тус тус зарцуулсан байна.



Зураг.4 Даатгуулагчдын тоо,  
9 сарын байдлаар



Зураг.5 Халамжид хамрагсдын тоо,  
9 сарын байдлаар



#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.

Нийгмийн даатгал: Иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын төрлүүд: Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан: Энэ нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг ойлгоно.



Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг ойлгоно




#### 1.4 Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр энэ улиралд 1185 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оноос 7.3 хувиар буюу 86 хүүхдээр өссөн байна. Нэг хүртэлх насандаа 23 хүүхэд эндсэн . Халдварт өвчнөөр 337 хүн өвчилсөн нь өнгөрсөн оноос 54.3 хувиар буюу 183 хүнээр буурсан байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн дотор трихомониазиар өвчлөгчид 11.3%, вируст гепатитаар өвчлөгчид 2.1%, сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 29.7% , тэмбүү , хүйтэн өвчнөөр өвчлөгчид 30.6% хувийг тус тус эзэлж байна.

Энэ улиралд 278 хүн нас барсан нь өнгөрсөн оноос 1.1 хувиар өссөн байна. Нийт нас барсан хүний 25.9 хувь нь эмнэлэгт нас барсан байна. Эхний 9 сарын байдлаар хорт хавдраар 71 хүн, осол гэмтлээр 36 хүн нас барсан байна,

Зураг.7 Эрүүл мэндийн байгууллагын үзлэгт хамрагдагсад

9 сарын байдлаар



#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нялхсын эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.




Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.




### 1.5 Гэмт хэрэг, шүүх

Цагдаагийн газрын мэдээгээр энэ онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 623 болж, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өссөн байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 23.3 хувийг хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг, 62.0 хувийг өмчлөх эрхийн эсрэг хэргүүд эзэлж байна. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн 47.9 хувийг малын хулгай эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлт 48.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.9 функтээр өссөн байна. Гэмт хэргийн улмаас нас барсан хүн 24 ба 148 хүн гэмтсэн. Байгууллага, иргэдэд 1639.8 сая төгрөгийн хохирол учирсан байна. Гэмт хэргийн улмаас гарсан нийт хохирлын 44.0 хувь буюу 721.5 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Нийт гарсан гэмт хэргийн 17.8 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. 487 жолоочийн жолоодох эрх хассан нь өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буюу 9 хүнээр өссөн үзүүлэлттэй гарчээ. Энэ сард 1196 хүн эрүүлжүүлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 26.6 хувь буюу 433 хүнээр буурчээ. Үүнээс 65 эмэгтэй эрүүлжүүлэгджээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 46.3 хувь буюу 56 хүнээр буурсан байна.

Зураг.8 Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо  
9 сарын байдлаар




Зураг.9 Бүртгэгдсэн гэмт хэрэг,  
9 сарын байдлаар





Энэ оны 3-р улиралд эрүүгийн хэрэг 208 шийдвэрлэж нийт 193 хүн ял шийтгүүлсэн байна. 96337.9 сая төгрөгийн торгох ял оногдуулжээ. Ялаас хугацаанаас нь өмнө 24 хүнийг тэнсэн сулласан байна. Иргэний хэрэг 563 шийвэрлэж 28459.3 мян төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамж гаргуулжээ. Захиргааны хэрэг 13 шийдвэрлэж 772.2 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж гаргуулсан байна.

Зураг.10 Шүүхээр шийдвэрлэсэн хэрэг,  
9 сарын байдлаар



#### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Гэмт хэрэг: Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18, түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг ойлгоно /МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 42.1 дэх заалт/.

Учирсан хохирол: Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь хүний эрх, эрх чөлөөний хир хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшнийг аль болох өмнө нь байсан хэмжээнд сэргээн бүрдүүлэхийг ойлгоно.

Сэжигтэн: МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 35.1-д заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэж, дор дурдсан этгээдийг сэжигтнээр тооцож, үндэслэл бүхий тогтоол гаргана:

Яллагдагч: МУ-ын “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн 36.1-д заасны дагуу энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг ойлгоно.



## I.6 Мөнгө, зээл

Банкны системийн хэмжээгээр өөрийн кассаар 40316.4 сая төгрөгийн орлогын, 40020.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, орлогоороо зарлагаа 100.0 хувь хангасан ба Монголбанк нь арилжааны банкуудад 1955.5 сая төгрөг хүргүүлж, банкуудаас 528.1 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Банкууд нь хадгаламжийн 30 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилж 91087.2 сая төгрөгийн хадгаламж хуримтлуулж ажилласан байна. Зээлийн өрийн үлдэгдэл 188060.1 сая төгрөгт хүрснээс чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2058.0 сая төгрөгт хүрч нийт зээлийн үлдэгдлийн 1.1 хувийг эзэлж байна. Жич Банк санхүү зээлийн мэдээллийг Монгол банкны Хэнтий аймаг дахь салбар гаргав.

Зураг.11 Зээл, хадгаламж, жил бүрийн  
9 сарын байдлаар /сая.төг/



### АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хэлцэл: Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг ойлгоно.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91- ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.



## I.7 Төсөв, санхүү

2019 оны 09 дүгээр сарын байдлаар төсвийн орлогод нийт 7524.0 сая төгрөг төвлөрөхөөс 9552.8 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2028.8 сая төгрөг буюу 27.0 хувиар төлөвлөгөө биелэсэн байна. Татварын бус орлогод төвлөрүүлэх ёстой 549.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг 78.3 хувиар давуулан биелүүлж, төсөвт татварын бус орлогоор 978.8 сая төгрөг төвлөрсөн байна. Орон нутгийн төсвийн байгууллага нийт 45436.8 сая төгрөгийн зарлагатай ажилласан нь төлөвлөснөөсөө 9046.7 сая төгрөгөөр бага зарцуулалттай ажилласан байна.

Зураг.12 Орон нутгийн төсөв, жил бүрийн  
9 сарын байдлаар /сая.төг/**АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:**

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсвийг хэлнэ.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл;

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

**1.8 Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2019 оны 09 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 9.0 хувь, өмнөх оны эцсээс 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт.13 Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 09 дугаар сар, бүлгийн дүнгээр

| Бараа үйлчилгээний бүлэг                      | 2019 IX      | 2019 IX      | 2019 IX      |
|-----------------------------------------------|--------------|--------------|--------------|
|                                               | 2018 IX      | 2018 XII     | 2019 VIII    |
| <b>Ерөнхий индекс</b>                         | <b>109.0</b> | <b>105.9</b> | <b>100.5</b> |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа         | 115.6        | 111.4        | 101.3        |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 104.1        | 103.9        | 100.0        |






|                                                     |       |       |       |
|-----------------------------------------------------|-------|-------|-------|
| Хувцас, бөс бараа, гутал                            | 105.6 | 103.9 | 100.6 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш     | 109.2 | 104.4 | 100.0 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа                  | 106.2 | 103.1 | 100.0 |
| Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ                      | 109.8 | 105.8 | 100.1 |
| Тээвэр                                              | 104.6 | 99.9  | 99.9  |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ             | 100.0 | 100.0 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ          | 101.9 | 101.4 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ                               | 111.5 | 111.5 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 115.8 | 112.2 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ                              | 110.2 | 107.1 | 100.0 |

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 9.0 хувиар өсөхөд** Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 5.6 хувь, Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 4.1 хувь, Хувцас, бөс бараа, гуталны бүлэг 5.6 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6.2 хувь, Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 9.8 хувь, Тээврийн бүлэг 4.6 хувь, Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.9 хувь, Боловсролын үйлчилгээний бүлэг 1.5 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 5,8 хувь, Бусад бараа, үйлчилгээний бүлэг 0.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 5.9 хувиар өсөхөд** Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.4 хувь, Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 3.9 хувь, Хувцас, бөс бараа, гуталны бүлэг 3.9 хувь, Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 4.4 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 3.1 хувь, Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 5.7 хувь, Тээврийн бүлэг 9.9 хувь, Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг.14 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар = 100)





АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, Ласпейресийн үнийн индексийн томъёогоор тооцож байна. Үүнд: Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг тооцоход ашиглаж байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.СЭДЭДМАА

2019 оны 09 дугаар сарын 15

**I. ХӨДӨЛМӨР****1.1 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, төрлөөр**

|                                                    | 2018 IX |                | 2019 IX |                | Зөрүү |
|----------------------------------------------------|---------|----------------|---------|----------------|-------|
|                                                    | Бүгд    | Үүнээс эмэгтэй | Бүгд    | Үүнээс эмэгтэй |       |
| Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд               | 635     | 364            | 456     | 268            | -179  |
| Тайлант сард нэмэгдсэн ажилгүйчүүд - бүгд          | 404     | 223            | 249     | 170            | -155  |
| Үүнээс: * орон тооны цомхотголоос                  | 13      | 8              | 7       | 1              | -6    |
| * байгууллага татан буугдсанаас                    | 2       | 0              | 2       | 1              | 0     |
| * өөр газраас шилжиж ирсэн                         | 40      | 22             | 12      | 11             | -28   |
| * сургууль төгссөн                                 | 86      | 46             | 61      | 45             | -25   |
| * цэргээс халагдсан                                | 1       |                | 2       |                | 1     |
| * мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх | 11      | 8              | 0       | 0              | -11   |
| * цалин багатайгаас                                | 25      | 14             | 12      | 11             | -13   |
| * бусад                                            | 226     | 125            | 101     | 77             | -125  |
| Ажилгүйчүүдээс тайлант сард ажилд орсон            | 141     | 59             | 48      | 59             | -93   |
| Үүнээс: * УУГ                                      | 1       | 0              | 1       | 1              | 0     |
| * Төрийн төсөвт байгууллага                        | 35      | 21             | 19      | 21             | -16   |
| * Нөхөрлөл, компани                                | 66      | 20             | 22      | 5              | -44   |
| * Хоршоо                                           | 1       | 1              | 4       | 1              | 3     |
| * Бусад                                            | 38      | 17             | 38      | 17             | 0     |
| Тайлант сард ажилгүйчүүдийн бүртгэлээс хасагдсан   | 388     | 193            | 255     | 193            | -133  |
| Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд             | 651     | 376            | 450     | 289            | -201  |

**II. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ****2.1 НИЙГМИЙН ХАЛАМЖ, төрлөөр**

|                                          | 2018 X                              |           | 2019 X                              |           |
|------------------------------------------|-------------------------------------|-----------|-------------------------------------|-----------|
|                                          | Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян.төг/ | Хүний тоо | Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян.төг/ | Хүний тоо |
| <b>Нийгмийн халамжийн сан, бүгд</b>      | 8716173                             | 37615     | 9061777.2                           | 47355     |
| <b>Халамжийн хэлбэр</b>                  |                                     |           |                                     |           |
| - Тэтгэвэр                               | 2107906.1                           | 1693      | 2315744.8                           | 1617      |
| - Тэтгэмж                                | 4133717.5                           | 15123     | 1707775.8                           | 3343      |
| - Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт       | 339621.4                            | 4710      | 272393.4                            | 4919      |
| - Тахир дутуу хүмүүст үзүүлсэн хөнгөлөлт | 165423.4                            | 370       | 96554.3                             | 1189      |
| <b>Нийт тэтгэмжээс:</b>                  |                                     |           |                                     |           |
| - Жирэмсний болон амаржсаны              | 1872099.4                           | 5308      | 217572                              | 1766      |
| - Өнчин хүүхдийг авч өсгөсний тэтгэмж    | 45264.7                             | 69        | 48911.9                             | 67        |
| Ихэр болон нярай хүүхдийн тэтгэмж        | 28000                               | 14        | 28000                               | 14        |



## Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга

|                                  |          |      |           |      |
|----------------------------------|----------|------|-----------|------|
| Хүүхэд асарсны тэтгэмж           | 173215.2 | 313  | 1661495.3 | 4788 |
| Ахмад настан болон бусад асаргаа | 521682.1 | 934  | 1028416.4 | 1732 |
| Ахмад дайчдад олгосон            | 3600     | 2    | 0         | 0    |
| - Алдарт эхийн одонтой эхчүүд    | 883980   | 6515 | 895100    | 6676 |
| Нийгмийн дэмжлэг туслалцаа       | 953000   | 5018 | 18000     | 12   |

## 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, төрлөөр

|                                      | Хэмжих нэгж | 2018 Х  | 2019 Х   | зөрүү   |
|--------------------------------------|-------------|---------|----------|---------|
| Олговол зохих тэтгэвэр               | сая.төг     | 30090.6 | 31760.2  | 1669.6  |
| Олгосон тэтгэвэр                     | "-          | 29021.5 | 31771.8  | 2750.3  |
| Нийт тэтгэвэр авагчид, бүгд          | тоо         | 10725   | 11067    | 342     |
| - өндөр настан                       | "-          | 7926    | 8295     | 369     |
| - тахир дутуу                        | "-          | 1535    | 1517     | -18     |
| - тэжээгчээ алдсаны                  | "-          | 639     | 623      | -16     |
| - цэргийн тэтгэвэр                   | "-          | 191     | 213      | 22      |
| - ҮОМШӨ тэтгэвэр                     | "-          | 434     | 419      | -15     |
| НДШ-ийн орлогын төлөвлөгөө           | сая.төг     | 11172.9 | 134343.9 | 123171  |
| гүйцэтгэл                            | "-          | 13930   | 16386.5  | 2456.5  |
| биелэлт                              | хувь        | 124.7   | 122.0    | -2.7    |
| НДШ-ийн нийт авлага                  | сая.төг     | 3018.3  | 1255.5   | -1762.8 |
| - Төсөвт байгууллага                 | "-          | 83.9    | 277.8    | 193.9   |
| - ААН, байгууллага                   | "-          | 2599.0  | 986.4    | -1612.6 |
| УНДЕГ-аас: - авах татаас             | сая.төг     | 16031.0 | 21270.0  | 5239    |
| - авсан                              | "-          | 16031.0 | 21270.0  | 5239    |
| биелэлт                              | хувь        | 100     | 100      | 0       |
| Ажилгүйдэл тэтгэмж : - авах хүн      | тоо         | 317     | 309      | -8      |
| - олгосон                            | сая.төг     | 351.4   | 461.7    | 110.3   |
| Эмнэлгүүдэд олговол зохих санхүүжилт |             | 2295.3  | 2327.2   | 31.9    |
| - олгосон                            |             | 2231.4  | 2327.2   | 95.8    |
| Даатгуулагч, бүгд                    | тоо         | 16299   | 16999    | 700     |
| - Заавал даатгуулагч                 | "-          | 11898   | 12623    | 725     |
| - Сайн дурын даатгуулагч             | "-          | 4401    | 4376     | -25     |

## III. СОЁЛ УРЛАГ

### 3.1 СОЁЛ УРЛАГ, төрлөөр

|                               | Хэмжих нэгж | 2018 Х | 2019 Х | Зөрүү   |
|-------------------------------|-------------|--------|--------|---------|
| Зохион байгуулсан арга хэмжээ | тоо         | 1623   | 585    | -1038   |
| Соёлын төвүүд                 | тоо         | 1585   | 550    | -1035   |
| АДБЧуулга                     | тоо         | 38     | 35     | -3      |
| Үзэгчид,бүгд                  | хүн         | 238140 | 100346 | -137794 |
| Соёлын төвүүд                 | хүн         | 216328 | 85452  | -130876 |
| АДБ чуулга                    | "-          | 17527  | 9808   | -7719   |



## Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга

|                               |         |         |         |          |
|-------------------------------|---------|---------|---------|----------|
| ОНС музей                     | -"      | 4285    | 5086    | 801      |
| <b>Орлого,бүгд</b>            | мян.төг | 35702.9 | 39757.3 | 4054.4   |
| Соёлын төвүүд                 | мян.төг | 18901.1 | 8122.8  | -10778.3 |
| АДБ чуулга                    | -"      | 16404.3 | 30305   | 13900.7  |
| ОНС музей                     | -"      | 397.5   | 1329.5  | 932      |
| <b>Номын сан, бүгд</b>        | тоо     | 23      | 23      | 0        |
| Төв номын сангийн суудлын тоо | тоо     | 60      | 60      | 0        |
| Нийт номын фонд               | мян.ш   | 193.8   | 93.7    | -100.1   |
| Нийт уншуулсан ном            | мян.ш   | 63.6    | 31.6    | -32      |
| Фондод шинээр авсан ном       | тоо     | 866     | 239     | -627     |
| Нийт уншигчдын тоо            | мян/хүн | 25.4    | 19.2    | -6.2     |

### IV. ЭРҮҮЛ МЭНД

#### 4.1 ЭРҮҮЛ МЭНД, төрлөөр

|                                                                 | Хэмжих нэгж | 2018 X  | 2019 X   | Зөрүү  |
|-----------------------------------------------------------------|-------------|---------|----------|--------|
| Төрсөн эх                                                       | тоо         | 1096    | 1179     | 83     |
| Амьд төрөлт                                                     |             | 1099    | 1185     | 86     |
| Төрөхийн улмаас эндсэн эх                                       |             | 0       | 0        | 0      |
| Нялхсын эндэгдэл: 0 - 1 нас                                     | -"          | 16      | 23       | 7      |
| 1 - 5 нас                                                       | -"          | 21      | 27       | 6      |
| Нас баралтын үзүүлэлтүүд                                        |             |         |          | 0      |
| Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1хүртэлх насандаа эндсэн хүүхэд | тоо         | 14.6    | 19.4     | 4.8    |
| Оны эцсийн 1000 хүн ам тутамд ногдох нас баралт                 | тоо         | 3.6     | 3.6      | 0      |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид                                      | тоо         | 520     | 337      | -183   |
| Үүнээс:- Менин                                                  | -"          | 0       | 0        | 0      |
| - Вируст гепатит                                                | -"          | 5       | 7        | 2      |
| - Тэмбүү                                                        | -"          | 123     | 67       | -56    |
| Цусан суулга                                                    | -"          | 45      | 19       | -26    |
| - Гахай хавдар                                                  | -"          | 2       | 3        | 1      |
| Хүйтэн                                                          |             | 51      | 36       | -15    |
| Бруцеллёз                                                       |             | 4       | 3        | -1     |
| - Трихомониаз                                                   |             | 54      | 38       | -16    |
| Сүрьеэ                                                          | -"          | 79      | 100      | 21     |
| Салхинцэцэг                                                     | -"          | 149     | 32       | -117   |
| Бусад                                                           |             | 8       | 9        | 1      |
| Нас баралт                                                      | -"          | 275     | 278      | 3      |
| Үүнээс: эмнэлэгт                                                | -"          | 49      | 72       | 23     |
| Нийт үзлэг                                                      | мян.хүн     | 239     | 24.2     | -214.8 |
| Урьдчилан сэргийлэх үзлэг эзлэх хувь                            | -"          | 30.5    | 30       | -0.5   |
| Эмчлүүлсэн хүн                                                  | -"          | 12.3    | 13.0     | 0.7    |
| <b>Хувийн эмнэлэг</b>                                           |             |         |          | 0      |
| - Үйлчлүүлсэн хүн                                               | тоо         | 7861    | 8156     | 295    |
| - Бүх орлого                                                    | мян.төг     | 77233.0 | 121236.0 | 44003  |

**V. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ****5.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр**

|                |                                                                                | 2018 Х      | 2019 Х      | Зөрүү      |
|----------------|--------------------------------------------------------------------------------|-------------|-------------|------------|
| <b>1</b>       | <b>Гэмт хэрэг, бүгд</b>                                                        | <b>465</b>  | <b>623</b>  | <b>158</b> |
| <b>Үүнээс</b>  | <b>ХҮНИЙ АМЬД ЯВАХ ЭРХИЙН ЭСРЭГ</b>                                            | <b>6</b>    | <b>14</b>   | <b>8</b>   |
|                | Хүнийг алах                                                                    | 5           | 1           | -4         |
|                | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх                                       | 1           | 12          | 11         |
|                | Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох                                       | 0           | 0           | 0          |
|                | <b>Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг</b>                                | <b>134</b>  | <b>145</b>  | <b>11</b>  |
| <b>Үүнээс</b>  | Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах                              | 0           | 0           | 0          |
|                | Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүй учруулах                           | 0           | 0           | 0          |
|                | Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах                         | 4           | 5           | 1          |
|                | Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах                            | 124         | 130         | 6          |
|                | Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх                                                  | 6           | 10          | 4          |
|                | <b>Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг</b>                        | <b>16</b>   | <b>11</b>   | <b>-5</b>  |
| <b>Үүнээс</b>  | Хүчиндэх                                                                       | 14          | 10          | -4         |
|                | Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах                                            | 2           | 1           | -1         |
|                | Бэлгийн мөлжлөг                                                                | 0           | 0           | 0          |
|                | <b>Өмчлөх эрхийн эсрэг</b>                                                     | <b>259</b>  | <b>386</b>  | <b>127</b> |
| <b>Үүнээс</b>  | Хулгайлах                                                                      | 127         | 129         | 2          |
|                | үүнээс - Хувийн өмчийг хулгайлах                                               | 117         | 125         | 8          |
|                | - Авто тээврийн хэрэгсэл хулгайлах                                             | 10          | 4           |            |
|                | - Халаасны хулгай                                                              |             |             |            |
|                | - Галт зэвсэг хулгайлах                                                        |             |             |            |
|                | Дээрэмдэх                                                                      | 2           | 3           | 1          |
|                | Залилах                                                                        | 18          | 37          | 19         |
|                | Хөрөнгө завших                                                                 | 11          | 15          | 4          |
|                | Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал            | 12          | 12          | 0          |
|                | Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх                                        | 0           | 0           | 0          |
| <b>Үүнээс</b>  | Эд хөрөнгийг утсгаж гэмтээх                                                    | 4           | 5           | 1          |
|                | Мал хулгайлах                                                                  | 85          | 185         | 100        |
|                | <b>Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг</b>                       | <b>1</b>    | <b>1</b>    | <b>0</b>   |
|                | <b>Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг</b> | <b>36</b>   | <b>27</b>   | <b>-9</b>  |
|                | <b>Бусад хэрэг</b>                                                             | <b>13</b>   | <b>39</b>   | <b>26</b>  |
|                | <b>Гэмт хэргийн илрүүлэлт %</b>                                                | <b>42.5</b> | <b>48.4</b> | <b>5.9</b> |
| <b>Хохирол</b> | Гэмт хэргийн улмаас - Нас барсан                                               | 15          | 24          | 9          |
|                | Гэмт хэргийн улмаас - Гэмтсэн                                                  | 36          | 148         | 112        |
|                | Учирсан хохирол /төг/                                                          | 1107.6      | 1639.8      | 532.2      |
|                | Нөхөн төлүүлсэн %                                                              | 27.8        | 44.0        | 16.2       |
|                | Эрүүлжүүлэгдсэн                                                                | 1629        | 1196        | -433       |
|                | үүнээс - эмэгтэй                                                               | 121         | 65          | -56        |
|                | Согтуугаар үйлдсэн                                                             | 76          | 111         | 35         |
|                | Бүлэглэн үйлдсэн                                                               | 31          | 64          | 33         |



## 5.2 ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ, төрлөөр

|                                          | Хэмжих нэгж | 2018 Х  | 2019 Х  | зөрүү    |
|------------------------------------------|-------------|---------|---------|----------|
| Шийдвэрлэсэн эрүүгийн бүх хэрэг          | тоо         | 232     | 208     | -24      |
| Ял шийтгүүлсэн бүх хүн                   | тоо         | 244     | 193     | -51      |
| Үүнээс: эмэгтэй                          | тоо         | 3       | 1       | -2       |
| Насанд хүрээгүй хүн                      | тоо         | 1       | 14      | 13       |
| Хорих ял оногдуулсан                     | тоо         | 38      | 72      | 34       |
| Үүнээс: Хорих ял биечлэн эдлүүлсэн       | тоо         | 35      | 72      | 37       |
| Торгох ял оногдуулсан                    | тоо         | 106     | 98      | -8       |
| Торгуулын дүн / мян.төг/                 | мян.мөг     | 90900.0 | 96337.9 | 5437.9   |
| Албадан ажил хийлгэх                     | тоо         | 57      | 23      | -34      |
| Тэнсэн харгалзсан                        | тоо         | 45      | 24      | -21      |
| Шийдвэрлэсэн иргэний хэрэг               | тоо         | 755     | 563     | -192     |
| Улсын тэмдэгтийн хураамж                 | мян.төг     | 48418.8 | 28459.3 | -19959.5 |
| <b>Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэсэн</b> | тоо         | 519     | 427     | -92      |
| Торгуулсан хүн                           | тоо         | 82      | 31      | -51      |
| Торгуулийн дүн                           | мян.төг     | 7415.9  | 4800.1  | -2615.8  |
| Баривчлагдсан хүн                        | тоо         | 437     | 376     | -61      |
| <b>Шийдвэрлэсэн захиргааны хэрэг</b>     | тоо         | 12      | 13      | 1        |
| Улсын тэмдэгтийн хураамж                 | мян.төг     | 1053.0  | 772.2   | -280.8   |

## VI. МӨНГӨ, ЗЭЭЛ

## 6.1 МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ, мян.төг

| Үзүүлэлт                     | 2018 Х       | 2019 Х       | Ү ү н э э с: |             |              |             |
|------------------------------|--------------|--------------|--------------|-------------|--------------|-------------|
|                              |              |              | Монгол банк  | ХААН банк   | Төрийн банк  | ХАС банк    |
| Кассын орлого /зузаатгалаар/ | 2,336,600.0  | 1,955,500.0  | -            | 1,502,600.0 | 452,900.0    | -           |
| Кассын цэвэр орлого          | 38,655,284.2 | 40,316,417.0 | -            | 6,289,730.4 | 30,218,421.6 | 3,808,265.0 |
| Кассын зарлага /шилжүүлэг/   | 758,980.0    | 528,140.0    | -            | 95,970.0    | 128,550.0    | 303,620.0   |
| Кассын цэвэр зарлага         | 35,963,762.9 | 40,020,261.3 | -            | 6,011,391.0 | 30,321,554.7 | 3,687,315.6 |
| Зээлийн                      |              |              |              |             |              |             |



Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга

|                                                                                                                      |                   |                   |   |                   |                  |              |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|-------------------|---|-------------------|------------------|--------------|
